**НИЙСЛЭЛИЙН**
**ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 05 сарын 07 өдөр        Дугаар А/90        Улаанбаатар хот

"Замын хөдөлгөөний Удирдлагын төв"
НӨТҮГ-ындaнс бүртгэлээс эргэлтийн
бус хөрөнгө хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2019 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 18 нэр төрлийн 43,672,732 /дөчин гурван сая зургаан зуун далан хоёр мянга долоон зуун гучин хоёр/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг "Замын хөдөлгөөний Удирдлагын төв" НӨТҮГ /Д.Одбаяр/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 2 нэр төрлийн 10,194,500 /Арван сая нэг зуун ерэн дөрвөн мянга таван зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 16 нэр төрлийн 33,478,232 /Гучин гурван сая дөрвөн зуун далан найман мянга хоёр зуун гучин хоёр/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг "Замын хөдөлгөөний Удирдлагын төв" НӨТҮГ /Д.Одбаяр/-т даалгасугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ                Ч.ОДНАСАН

D:\Tushaal 2019\Tushaal-1\Тушаал 2019.docx

11505000331

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 05......сарын
07.. өдрийн 14 дүгаар тушаалын хавсралт

Данснаас хасах эргэлтийн бус хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: "Замын Хөдөлгөөний удирдлагын төв"НӨТҮГ /төгрөг/

| № | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | ЭБХХХК-ын хурлын шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | LCD дэлгэц | 7 | ш | 15 | 652,500 | 9,787,500 | 8,564,062 | 1,223,438 | актлах /*сэлбэгийн зориулалтаар үлдээх*/ |
| 2 | Ашиглалтын компьютер /оператор/ | 7 | ш | 2 | 3,239,111 | 6,478,222 | 6,478,222 | - | татах |
| 3 | Жи-мобайл утас | 6 | ш | 20 | 200,000 | 4,000,000 | 4,000,000 | - | татах |
| 4 | Зөөврийн компьютер | 9 | ш | 1 | 1,155,000 | 1,155,000 | 1,155,000 | - | татах |
| 5 | Зургийн аппарат /NIKO-COOLPIX-S/ | 7 | ш | 7 | 269,900 | 1,889,300 | 1,889,300 | - | татах |
| 6 | Компьютер DELL OPTIPLEX-7020 | 3 | ш | 2 | 2,960,927 | 5,921,854 | 4,441,390 | 1,480,464 | татах |
| 7 | Проектор /танилцуулгын өрөө/ | 7 | ш | 1 | 1,000,000 | 1,000,000 | 875,000 | 125,000 | татах |
| 8 | Проектор /дэлгэц/ | 7 | ш | 1 | 500,000 | 500,000 | 437,500 | 62,500 | татах |
| 9 | Согтолтын хувь хэмжигч | 6 | ш | 1 | 880,000 | 880,000 | 880,000 | - | татах |
| 10 | Удирдлага | 7 | ш | 1 | 1,000,000 | 1,000,000 | 875,000 | 125,000 | татах |
| 11 | Хард диск /тера2/ | 9 | ш | 2 | 203,500 | 407,000 | 407,000 | - | актлах |
| 12 | Хэвлэгч /HP2055/ | 7 | ш | 2 | 2,760,000 | 5,520,000 | 4,830,000 | 690,000 | татах |
| 13 | Чихэвч /HD660/ | 7 | ш | 1 | 100,000 | 100,000 | 100,000 | - | татах |
| 14 | Утасгүй микрофон | 7 | ш | 1 | 500,000 | 500,000 | 437,500 | 62,500 | татах |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | Дарга сандал | 9 | ш | 1 | 714,780 | 714,780 | 643,302 | 71,478 | татах |
| 16 | Зөөврийн компьютер | 8 | ш | 1 | 2,782,076 | 2,782,076 | 2,782,076 | - | татах |
| 17 | компьютер /DELL VOSTRO/ | 9 | ш | 1 | 868,000 | 868,000 | 868,000 | - | татах |
| 18 | Шарах шүүгээ | 9 | ш | 1 | 169,000 | 169,000 | 169,000 | - | татах |
| | Нийт дүн | | | 61 | | 43,672,732 | 39,832,352 | 3,840,380 | |
| Актлах хөрөнгө | | | | | | 10194500 | | | |
| Татан төвлөрүүлэх хөрөнгө | | | | | | 33478232 | | | |